БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

БАТЛАВ.
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ТӨМӨРХҮҮ

"ШИНЭ ХАРХОРУМ" ХОТЫН II ЭЭЛЖИЙН АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ /ХАРХОРИН СУМ- ХӨШӨӨ ЦАЙДАМ-ӨГИЙ НУУР-ДАШИНЧИЛЭН ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМТАЙ ХОЛБОХ/ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 03 дугаар сарын 21 Дугаар 2025/05/А/67 Улаанбаатар хот

1.	Үндэслэл	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 230 дугаар зарлиг "Хархорум хотыг сэргээн байгуулах тухай"; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого; - Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоол "Орхоны хөндийд Шинэ Хархорум хот байгуулах тухай"; - Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоол "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" батлах тухай; - Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль; - Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль; - Монгол Улсын Их Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 17 дугаар тогтоол, "Хархорум" хотын эдэлбэр газрын хил заагийг батлах тухай"; - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэх ажлын "Жагсаалт батлах тухай" 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тушаал.
2.	Бүрдэл	Ажил тус бүр нь Техник эдийн засгийн үндэслэл, Инженерийн нарийвчилсан зураг төсөл гэсэн бүрдэлтэй байна. ▪ Хархорум сумаас Хөшөө Цайдам чиглэлийн А28 дугаар замын 20 дахь км орчмоос төгсгөл хүртэл авто замыг өргөтгөх, шинэчлэх ажил ▪ А28 дугаар замын төгсгөлөөс Өгий нуур чиглэлд Мянганы замтай холбох хатуу хучилттай шинэ авто замын ажил
3.	Байршил	Архангай аймгийн Хашаат, Өгий нуур, Өлзийт сум, Булган аймгийн Могод, Гурванбулаг сумын нутаг дэвсгэрийн хэсгүүд хамрагдана (Хавсралт № 3)
4.	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар

5.	Замын техникийн ангилал, замын зэрэглэл	Техник эдийн засгийн үндэслэлээр нарийвчлан тогтоосноор 4-өөс доошгүй эгнээ байна (Захиалагчтай зөвшилцөнө)
6.	Замын эхлэлийн цэг	Хархорум хот (Онгоцон хөндий орчим), Техник эдийн засгийн үндэслэлээр тогтоосон цэгээс эхэлнэ (Захиалагчтай зөвшилцөнө)
7.	Замын төгсгөлийн цэг	Мянганы зам (Өгий нуур орчим), Техник эдийн засгийн үндэслэлээр тогтоосон цэг (Захиалагчтай зөвшилцөнө)
8.	Замын хучилтын хийц	Зургийн ерөнхий инженерийн техникийн шийдэл, инженер геологийн судалгааны үр дүнд замын хучилтын хийцийг тооцоогоор оновчтой сонгох (Захиалагчтай зөвшилцөнө)
9.	Төлөвлөлтийн норм ба дүрэм, стандарт	- "Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016; - "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНбД 81-013-2019; - "Хот суурины гудамж төлөвлөлт" БНбД 32-01-04; - "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30.01.04; - "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" АЗУАГН 2.01.01-2004; - "Ус зүйн тодорхойлолтыг тооцоолох норм ба дүрэм" БНбД 2.01.14-86; - "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНбД 22.01.01; - "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-19 II хэсэг инженер Геодезийн ажил - "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНбД 32-02-12; - "Авто зам, гүүр, инженерийн хангамжийн сүлжээнд газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх аргачлал" БД 22-104-18; - "Хот тосгон ба суурин газрын гудамж талбай, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх дүрэм БД 30-102-11; - "Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм" БД 40-302-13; - "Авто зам болон төмөр замын геодезийн ажил" БД11-114-14; - Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/ барилгын дүрэм; - "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4607 2014; - "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS 4596-2014; - "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056-2009; - "Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага" MNS 6808-2019; - Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598-2020; - "Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг. Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000" MNS 6736-2018; - Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц MNS6515:2015; - Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарц Ерөнхий шаардлага MNS6735:2018; - "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам";

		- Бусад шаардлагатай хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол улсын холбогдох ЗЗБНбД, БНбД болон стандартуудыг хатуу баримтлан, тэдгээрт бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ.
10.	ТЭЗҮ, зураг төсөл гүйцэтгэх хугацаа, үе шат	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд гэрээ байгуулж 150 хоногийн хугацаанд зураг төслийн ажлыг 2 үе шаттай гүйцэтгэнэ. 1. ТЭЗҮ боловсруулах /60 хоног/ 2. Инженерийн нарийвчилсан зураг төсөл /90 хоног/
11.	ТЭЗҮ-ийн тайлангийн иж бүрдэл, тавигдах шаардлага	1. Техник эдийн засгийн үндэслэлийн судалгаанд инженерийн хайгуул судалгаа, буурь хөрсний инженер-геологийн судалгаа, замын үндсэн материалын судалгаа, трассын дагууд хамрагдаж байгаа түүх, соёлын дурсгалын судалгаа, инженер геодезийн судалгаа, хэтийн хөдөлгөөний эрчмийн судалгаа, авто замын трассын хувилбарууд болон сонголт, урьдчилсан төлөвлөлт, ажлын тоо хэмжээ, барилга угсралт, засвар арчлалтын ажилд шаардагдах хөрөнгийн тооцоо, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, хөрөнгө оруулалтын үр ашиг, мэдрэмжийн шинжилгээ, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга зам зэрэг багтана. ("Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016 нормын 2-8 дугаар хавсралтыг ашиглах) 2. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулахтай холбогдолтой бүх асуудлыг энэхүү даалгаврын Хавсралт №1-д тусгасан жишиг бүтцийн дагуу тайланд бүрэн тусгана; 3. Төлөвлөж байгаа авто замын Техник эдийн засгийн үндэслэлийн тайланг Зам, тээврийн яамны дэргэдэх Авто замын салбарын Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох дүгнэлтийг тайланд хавсарган захиалагчид хүргүүлэх; 4. Төлөвлөж буй авто замын трассыг тогтоохдоо тухайн бүс нутагт баригдсан, одоо баригдаж байгаа авто зам болон цаашид тухайн бүс нутагт баригдахаар төлөвлөж байгаа авто зам, төмөр замтай огтлолцох цэгүүдийг оновчтой тогтоох, хөдөлгөөний аюулгүй байдлын дүгнэлт гаргах, холбогдох байгууллагуудаас санал зөвлөмж авч тайланд тусгах; 5. Батлагдсан ТЭЗҮ-ийн тайланг Монгол, Англи эх хувь 1ш, хуулбар тус бүр 2ш хүлээлгэн өгөх /хуулбар хувийг өнгөтөөр хувилах/; 6. Тоон хэлбэрээр /*dwg, *kmz, *pdf/ хүлээлгэж өгнө. Тоон байдлаар бүх бичиглэлийн материалыг *.doc, *.xls өргөтгөлтэйгөөр, зураглалын материалыг *.dwg, *.shp өргөтгөлтэйгөөр баримт бичгийн бүрдлийг *.pdf, *.pptx өргөтгөлтэйгөөр CD болон DVD-ээр хүлээлгэн өгнө.
12.	Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдэл, тавигдах шаардлага	**Авто замын ажлын иж бүрэн зураг төсөл:** 1. Тухайн авто замыг барьж бүрэн дуусгахад шаардлагатай (Нийтийн тээвэрт зориулсан түр зам, газрын өнгөн хөрс хуулах, ус өнгөрүүлэх хоолой ба ус зайлуулах бусад байгууламж, гүүр, ул хөрс солих, цэвдгийг гэсэлтээс хамгаалахад зориулсан дулаан тусгаарлах ба чулуун асгасан үе, шороон далан, ухмал, далангийн дээд үе,

		тусгай үеүд, суурийн дэвсгэр үе, замын суурь ба хучлага, ан амьтныг хөндлөн гаргах байгууламж, замын тоноглол, бетон барьер, хөдөлгөөн зохицуулалтын ба аюулгүй байдлын хэрэгслүүд, тэмдэг ба тэмдэглэл, зогсоол ба амрах талбай, зам, гүүрийн барилгын зурваст орсон шилэн кабелийг хамгаалах, цас хунгарлалтыг багасгах хэрэгсэл зэрэг) бүх төрлийн ажлын (гэхдээ эдгээрээр зөвхөн хязгаарлагдахгүй) нарийвчилсан зураг; 2. Авто замын зураг төсөлд тусгагдсан бүх ажлын техникийн шаардлага (ТШ); 3. Авто замын зураг төсөлд тусгагдсан бүх төрлийн ажлын болон барилгын нийт ажлын тоо хэмжээний жагсаалт (АТХЖ); 4. Төсөвт өртгийн нэгдсэн тооцоо (ТӨНТ); 5. Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ); 6. "Геодези зураг зүйн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" /БНбД 11-07-19/-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Авто зам болон төмөр замын геодезийн ажил" /БД 11-114-14/-д тавигдах шаардлагын дагуу байр зүйн хэмжилтийн ажлын тайлан; 7. Зам барилгын ажилд хэрэглэх түгээмэл тархацтай (чулуу, далан, суурийн хайрга, хөрс гэх мэт) материалын тойм судалгаа болон буурь хөрс, замын далангийн материалын судалгааг хамруулсан инженер-геологи, геотехникийн хайгуул судалгааны ажлын тайлан; 8. Гадаргуугийн усны ба цаг уурын судалгааны дэлгэрэнгүй тайлангаас бүрдэнэ. 9. Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдэл тус бүрийг захиалагчаар хянуулж, зөвшилцсөний дараа Магадлалын нэгтгэсэн дүгнэлт гаргуулах бөгөөд баталгаажсан зураг төслийг Монгол-Англи хэл дээр хөрвүүлж тус бүр эх хувь 1ш, хуулбар 2ш захиалагчид акт үйлдэн хүлээлгэн өгнө. /өнгөтөөр хувилах/, 10. Төсөллөлтийг гүйцэтгэхдээ шаардлагатай тохиолдолд Захиалагчтай зөвшилцөх, Инженерийн нарийвчилсан зураг боловсруулахтай холбогдолтой бүх асуудлыг энэхүү даалгаврын Хавсралт № 2-д тусгасан жишиг бүтцийн дагуу Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ)-д бүрэн тусгана; 11. Тухайн газар орны газрын гадаргуугийн зураг, үндсэн реперийн сүлжээ, элемент тус бүрийн төсөллөлтөд ашигласан шалгуур үзүүлэлтүүд, анхны төсөөлөл, загвар, хэрэглэсэн арга, тооцооллын хураангуй, материалын туршилтын үр дүн зэргийг хамруулан, цуглуулсан бүх өгөгдлийг ИДТ-д хавсаргах; 12. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар"-аас геодезийн цэгийн солбицол, өндрийг авах бөгөөд замын трассын дагуу зураглалын сүлжээ байгуулж геодезийн ажлын тайлан болон холбогдох мэдээллийг актаар хүлээлгэн өгөх, ИДТ-д хавсаргах; 13. Авто замын барилгын ажилтай холбоотой газар олгосон болон шороон орд ашиглах орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл, техникийн нөхцөлүүдийг авч ИДТ-д хавсаргах;

		14. Тоон хэлбэрээр /*dwg, *kmz, *pdf/ хүлээлгэж өгнө. Тоон байдлаар бүх бичиглэлийн материалыг *.doc, *.xls өргөтгөлтэйгөөр, зураглалын материалыг *.dwg, *.shp, *jpg өргөтгөлтэйгөөр баримт бичгийн бүрдлийг *.pdf, *.pptx өргөтгөлтэйгөөр CD болон DVD-ээр хүлээлгэн өгнө.
13.	ТЭЗҮ, ИНЗ боловсруулах байгууллага	Зам, тээврийн яамны холбогдох тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага. Үүнд: 5.2.1 Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах; 5.2.2 Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тус тус тусгай зөвшөөрөлтэй байх
14.	Захиалагч байгууллага	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
15.	Онцгой нөхцөл	- Зайлшгүй шаардлагатай тохиолдолд олон улсад түгээмэл хэрэглэгддэг зохих стандарт, нормыг захиалагчтай зөвшилцөж ашиглаж болно; - Байгалийн гамшиг, газар хөдлөлийн эрсдэлээс үзүүлэх нөлөөллийг тооцох, халиа тошин, үер, уруйгаас хамгаалах байгууламжийг төсөллөх; - Малын бэлчээр, зэрлэг ан амьтдын шилжих хөдөлгөөнийг хязгаарлахгүй, амьдралын хэвшлийг өөрчлөхгүй, бэлчээр сэлгэх нүүдлийг саадгүй нэвтрүүлэх боломжоор хангасан шийдэл боловсруулах, экологийн гарц төлөвлөх; - Авто зам, замын байгууламжийг элс болон цаснаас хамгаалах инженерийн шийдлийг ТЭЗҮ-ийн шатанд тодорхойлсны дагуу төсөллөх; - Авто замын дагуу зогсоол, амрах талбай, үйлчилгээний байгууламж, шаардлагатай тохиолдолд том оврын тээврийн хэрэгслийн зогсоолын талбайг ТЭЗҮ-ээр тодорхойлсны дагуу холбогдох норм дүрмийг үндэслэн төсөллөх; - Суурин газруудад гэрэлтүүлэг болон цахилгаан хангамж, явган хүний аюулгүй байдлыг хангасан гарц, гэрлэн дохио суурилуулахаар төсөллөх; - Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын тор хэмжээг гаргаж, зураг төсөлд тусгах; - Төсөвт өртгийн нэгдсэн тооцоо (ТӨНТ)-г үе шаттай хэрэгжүүлэх боломжтой байдлаар авто замын чиглэл, ангиллаар нь тус тусад нь тооцох; - Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд нарийвчлан төсөллөх, хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийлгэх; - Авто замын трасст өртөж буй барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний нүүлгэн шилжүүлэх ажлын нарийвчилсан зураг төсөл, зардлын тооцоог гаргах; - Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газраас санал авч шаардлагатай тохиолдолд төлбөр хураах цэгийн барилгын зураг төслийг хийх; - Авто замын хөндлөн огтлолыг 20м тутамд боловсруулах;

		- Гүйцэтгэгч нь бүх өгөгдөл, инженерийн нарийвчилсан зураг, баримт бичгийн үнэн зөв, иж бүрдлийг бүрэн хариуцах бөгөөд шаардлагатай бол барилга угсралтын ажлын тендер шалгаруулалтын үед зохих тодруулгыг өгнө; - Авто зам, замын байгууламжийн үндсэн элементүүдийг авто замын бүртгэл мэдээллийн сангийн бүтэц бүрэлдэхүүний дагуу мэдээллийг боловсруулж цахим хэлбэрт замын шинж чанарын мэдээллийг үүсгэж "замын мэдээллийн сан"-д оруулан баталгаажуулах; - Зургийн байгууллага хариуцлагын даатгалд хамрагдсан байх.

ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

ТЭЗҮ нь дараах заалтуудаар хязгаарлагдахгүй бөгөөд доор дурдсанаас бусад тооцоо судалгааг төслийн онцлогоос хамааруулан хийх шаардлагатай. ("Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016 нормын 2-8 дугаар хавсралтын дагуу)

НЭГ. ИНЖЕНЕРИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

1.1 Авто замын хайгуул судалгаа
- Замын чигийн сонголт
- Хувилбаруудын харьцуулалт
- Байр зүйн судалгаа
- Зам-цаг уур болон уур амьсгалын хүчин зүйлсийн нөхцөл нөлөөлөл, онцлог, даван гарах арга зам
- Инженер геологийн судалгаа, хүчин зүйлсийн нөхцөл нөлөөлөл, онцлог, даван гарах арга зам
- Гидрологийн судалгаа ...

1.2 Урьдчилсан төсөллөлт
- Төсөллөлтийн стандарт ба шалгуурууд
- Хучилтын бүтээц, хиймэл байгууламжуудын төсөллөлтийн хувилбарууд, харьцуулалт сонголт
- Гүүр хоолой бусад хиймэл байгууламжуудын төсөллөлт
- Томоохон уулзвар, орц, гарцуудын төсөллөлт
- Орон нутгийн ард иргэдийг саадгүй зорчуулах боломжоор хангасан төсөллөлт
- Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төсөллөлт
- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан
- Хувилбаруудын урьдчилсан төсөв, харьцуулалт
- Авто зам, замын байгууламжийн цаашдын ашиглалт, засвар, арчлалт, хамгаалалтын төлөвлөлт ...

1.3 Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, зөвлөмж
- Төсөл хэрэгжүүлэх аргачлал
- Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө (шаардлагатай тохиолдолд бүтээн байгуулалтыг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөх)
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө
- Зөвлөмж ...

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2.1 Монгол Улсын болон бүс нутгийн нийгэм эдийн засгийн байдал
- Хүн ам, нутаг дэвсгэрийн хөгжилд төслийн замаас үзүүлэх нөлөө
- Эдийн засгийн хөгжилд төслийн замаас үзүүлэх нөлөө
- Аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, дэд бүтэц, аялал жуулчлал, нийгмийн бусад салбаруудад төслийн замаас үзүүлэх нөлөө
- Нийгмийн хөгжил, улс, орон нутаг, бүс нутгийн төсөв, үнэ тарифт уг төслийн үзүүлэх нөлөө
- Нийгмийн бусад салбаруудад төслийн замаас үзүүлэх нөлөө

2.2 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний өнөөгийн байдал болон цаашдын чиг хандлага
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн хэтийн судалгаа
- Хөдөлгөөний эрчмийн шинжилгээ
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн өөрчлөлт

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн хэтийн өсөлтийн талаарх төсөөлөл
- Аялал үүсэх, шингэх цэгийн судалгаа
- Тэнхлэгийн ачааллын судалгаа
- Стандарт тэнхлэгийн ачааллын тооцоо

2.3 Төсөллөж буй авто замын хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийн шинжилгээ
- Тээвэр ашиглалтын зардал, төсөл хэрэгжсэн үеийн тээвэр ашиглалтын зардлын хэмнэлт
- Зам хэрэглэгчийн зардал, төсөл хэрэгжсэн үеийн зам хэрэглэгчийн зардлын хэмнэлт
- Тээврийн хэрэгслийн осол аваарын судалгаа, төсөл хэрэгжсэн үеийн осол аваар бууралтаас гарах хэмнэлт
- Төслийн хөрөнгө оруулалтын үр ашиг, өнөөгийн цэвэр үнэ
- Мэдрэмжийн шинжилгээ
- Эдийн засгийн ач холбогдол

2.4 Төлөвлөж буй авто замын хөрөнгө оруулалтын нийгэм эдийн засгийн үр ашгийн шинжилгээ
- Нийгэм эдийн засгийн судалгаа
- Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаа
- Ядуурлыг бууруулахад үзүүлэх нөлөөлөл
- Мэдрэмжийн шинжилгээ
- Нийгэм эдийн засгийн ач холбогдол

2.5 Төслийн хураангуй тайлан ...

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

3.1 Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

3.2 Түүх соёлын дурсгалт зүйлсийн судалгаа хамгаалах арга зам

3.3 Төслийн авто замаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, урьдчилсан үнэлгээ, зардал

3.4 Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө ("Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016 нормын хавсралт 2-ыг ашиглах) ...

ДӨРӨВ. ХАВСРАЛТ

- Авто замын салбарын ШУТЗ-ийн хурлаас гарсан санал, дүгнэлт
- Ажлын даалгаварт тусгасан холбогдох санал, зөвшөөрлүүд ...

ИНЖЕНЕРИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

ИДТ нь дараах заалтуудаар хязгаарлагдахгүй бөгөөд доор дурдсанаас бусад тооцоо судалгааг төслийн онцлогоос хамааруулан хийх шаардлагатай.

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Ерөнхий
1.2. Зураг төсөл боловсруулах үндэслэл
1.3. Зам барилгын ажилтай холбогдолтой газар олголтын талаарх захирамж, шийдвэр зөвшөөрөл
1.4. Холбогдох газруудаас олгосон техникийн нөхцөл
1.5. Захиалагчаас хангасан өгөгдөл
1.6. Зураг төслийг боловсруулахад мөрдлөг болгосон норм, стандартууд
1.7. Зураг төслийн товч танилцуулга, бүрэлдэхүүн
1.8. Төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд ба сонголт ...

ХОЁР. ХАЙГУУЛ СУДАЛГАА

2.1. Төслийн бүс нутгийн байгаль орчны нөхцөл байдал
   - Физик газарзүйн нөхцөл, уур амьсгал
   - Авто замын уур амьсгалын нөхцөл
   - Хөрс
   - Амьтны аймаг ...
2.2. Замын одоогийн байдал, трасс сонголт
   - Төмөр замын огтлолцлууд
   - Хоолойн үзлэг
   - Гүүрийн үзлэг
   - Хар цэг буюу осол аваар ихээр гардаг цэгийн судалгаа ...
2.3. Замын дагуух буурь хөрсний болон карьерын судалгаа
2.4. Байр зүйн зураглал
2.5. Ус зүйн судалгаа
2.6. Инженерийн шугам сүлжээний судалгаа
2.7. Газар эзэмшилтийн байдал
2.8. Археологийн тандалт, судалгаа ...

ГУРАВ. ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

3.1. Стандарт шалгуур үзүүлэлтүүд, замын үндсэн элементүүдийн сонголтууд
3.2. Авто замын төлөвлөлт
   - Замын трасс сонголт, хэвтээ төлөвлөлт
   - Замын дагуу төлөвлөлт
   - Замын хөндлөн огтлол төлөвлөлт
   - Хучилтын хийц төлөвлөлт
   - Хөдөлгөөн зохион байгуулалт, тоноглол ...
3.3. Хиймэл байгууламжийн төлөвлөлт
   - Гүүрийн төлөвлөлт
   - Төмөрбетон хоолойн төсөллөлт
3.4. Уулзвар, гарц, зогсоолын төлөвлөлт
3.5. Түр замын төлөвлөлт
3.6. Авто замын трасст орсон зайлуулагдах барилга, байгууламж
3.7. Байгалийн нөхөн сэргээлтийн талаар
3.8. ИНЗ-ийг хэрхэн боловсруулсан талаарх ерөнхий тайлбар
3.9. Боловсруулалтын дунд шатанд хянаж дүгнэсэн ба захиалагчаас гаргасан нэмэлт саналыг тусгасан талаар

ДӨРӨВ. ХАВСРАЛТ

- Цооногийн бичиглэл
- Геодезийн байнгын цэг тэмдэгтийн хувийн хэрэг
- Хучилтын тооцоо
- Ажлын тоо хэмжээ
- Ажлын даалгавар
- Магадлалын ерөнхий дүгнэлт
- Ажлын даалгаварт тусгасан холбогдох акт, зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд ...

ТӨЛӨВЛӨЖ БУЙ АВТО ЗАМЫН ТРАССЫН ЧИГ /УРЬДЧИЛСАН БАЙДЛААР/